




ГАМШГААС ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨ

БОЛОВСРУУЛСАН:
ДОТООД ХЯНАЛТ ХАРИУУЛСАН
МЭРГЭЖИЛТЭН 
Б.БАТ-ӨДЗИЙ

ХЯНАСАН:
ХЭЛТСИЙН ОРЛОГЧ, ГАМШГААС ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨЛТ
БЭЛЭН БАЙДАЛ ХАРИУЦСАН АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН,
ГАМШГААС ХАМГААЛАХ УЛСЫН ХЯНАЛТЫН АХЛАХ БАЙЦААГЧ
ХОШУУЧ 
А.ТҮВШИНБААТАР

Боловсруулсан: 2021 оны ... дугаар сарын өдөр

Тодотгосон: он сар өдөр
..... он сар өдөр
..... он сар өдөр

УЛААНБААТАР ХОТ

2021 ОН

ГАДААДЫН ИРГЭН, ХАРЬЯАТЫН ГАЗАР

Дотоод товьёог

№	Баримтын тэргүүн	Хуудасны дугаар	Тайлбар
1	“Гамшгаас хамгаалах орон тооны бус штаб, бүлэг байгуулах тухай” Гадаадын иргэн, харьяатын газрын даргын тушаал, түүний хавсралт	1-14	
2	Гамшгийн үед ажиллах журам	15-18	
3	Байгууллагын товч танилцуулга	19	
4	Монгол Улсад тохиолдож болзошгүй гамшиг, түүний дүгнэлт	20-23	
5	Гамшгийн үед ажиллах төлөвлөгөө	24-29	
6	Гадаадын иргэн, харьяатын газрын албан хаагчдын утасны жагсаалт	30-36	
7	Онцгой нехцел байдал, гамшиг тохиолдсон үед албан хаагчдад зарлан мэдээлэл хүргэх бүдүүвч	37-46	
8	Гамшиг ослын үед байгууллагад учирч болох хохирол, гал түймрийн бараж хэрэгсэл	47-48	
9	Тээврийн хэрэгслийн судалгаа	49	
10	Ослын үед байгууллагаас гарах гарцын бүдүүвч зураг /давхар тус бүрээр/	50-56	
11	Схем зураг. Гамшиг ослын үед алба хаагчид цугларах цэгийн байршил	57-58	
12	Гамшгаас хамгаалах төлөвлөгөөтэй танилцсан албан тушаалтан	59	

---ooOoo---

Гадаадын иргэн, харьяатын газрын даргын 2021
оны 1/93дугаар тушаалын нэгдүгээр хавсралт

ГАМШГААС ХАМГААЛАХ ОРОН ТООНЫ БУС
ШТАБЫН БҮРЭЛДЭХҮҮН



Штабын дарга

Дэд дарга

Гишүүд:

Сургалт, сурталчилгаа хариуцсан бүлэг:

Захиргаа, удирдлагын газрын дарга

Архивын баримтыг нүүлгэн шилжүүлэх бүлэг:

Виз, зөвшөөрлийн газрын дарга

Эмнэлгийн тусlamж, үйлчилгээ үзүүлэх бүлэг:

Иргэний харьяаллын газрын дарга

Хэв журам сахиулах бүлэг:

Зөрчил шалган шийдвэрлэх газрын дарга

Нөөц, хангарт хариуцсан бүлэг:

Санхүүгийн хэлтсийн дарга

Гал унтраах, аврах бүлэг:

Хангарт, үйлчилгээний хэлтсийн дарга

Холбоо зарлан мэдээлэл хариуцсан бүлэг:

Мэдээллийн технологийн хэлтсийн даргын
үүргийг түр орлон гүйцэтгэгч

Гадаад харилцаа, хамтын ажиллагаа хариуцсан бүлэг:

Гадаад харилцаа, хамтын ажиллагааны
хэлтсийн дарга

Эрсдлийн үнэлгээ хариуцсан бүлэг:


Хяналт-шинжилгээ, үнэлгээ, аудитын
хэлтсийн дарга

Штабын нарийн бичгийн дарга

Дотоод хяналт, аюулгүй байдал хариуцсан
ахлах мэргэжилтэн

Гадаадын иргэн, харьяатын газрын даргын 2021
оны 10 дугаар тушаалын хоёрдугаар хавсралт

СУРГАЛТ, СУРТАЛЧИЛГАА ХАРИУЦСАН БҮРЭЛДЭХҮҮН



Бүлгийн дарга:

Захиргаа, удирдлагын газрын дарга

Гишүүд:

Тайлан, төлөвлөгөө хариуцсан ахлах мэргэжилтэн

Хүний нөөц, сургалт хариуцсан
ахлах мэргэжилтэн

Тогтоол шийдвэрийн биелэлт хариуцсан
ахлах мэргэжилтэн

Хуулийн ахлах мэргэжилтэн

Орон нутаг хариуцсан ахлах мэргэжилтэн

Олон нийттэй харилцах ахлах мэргэжилтэн

Нууц хариуцсан мэргэжилтэн

Хуулийн мэргэжилтэн

Сургалт хариуцсан хүний нөөцийн мэргэжилтэн

Хувийн хэрэг хариуцсан
хүний нөөцийн мэргэжилтэн

Жендер, шагнал хариуцсан
хүний нөөцийн мэргэжилтэн

Дотоод ажил, судалгаа хариуцсан
хүний нөөцийн мэргэжилтэн

Тушаалын хэрэгжилт хариуцсан мэргэжилтэн

Өргөдөл гомдол хариуцсан мэргэжилтэн

Ахлах архивч–операторч

Сан хөмрөгийн эрхлэгч

Бичиг хэргийн эрхлэгч

Бичээч

Гадаадын иргэн, харьяатын газрын даргын 2021
оньш/өз дугаар тушаалын гуравдугаар хавсралт

АРХИВЫН БАРИМТЫГ НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ БҮЛГИЙН БҮРЭЛДЭХҮҮН



Бүлгийн дарга:

Виз, зөвшөөрлийн газрын дарга

Гишүүд:

Виз, зөвшөөрөл хариуцсан ахлах мэргэжилтэнүүд

Оршин суух хариуцсан ахлах мэргэжилтэн

Цагаач хариуцсан ахлах мэргэжилтэн

Зөвлөгөө мэдээлэл хариуцсан ахлах мэргэжилтэн

Виз, зөвшөөрлийн мэргэжилтэнүүд

Цагаач хариуцсан мэргэжилтэнүүд

Зөвлөгөө мэдээлэл хариуцсан мэргэжилтэнүүд

Гадаадын иргэн, харьяатын газрын даргын 2021
оны 16 дугаар тушаалын дөрөвдүгээр хавсралт

ЭМНЭЛГИЙН ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭХ БҮЛГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Бүлгийн дарга:

Иргэний харьяаллын газрын дарга

Гишүүд:

Их эмч

Харьят хариуцсан ахлах мэргэжилтэн

Харьят болох асуудал хариуцсан мэргэжилтэн


Харьяатаас гарах асуудал хариуцсан мэргэжилтэн

Хүүхэд үрчлэлт, төрийн бус байгууллага
хариуцсан мэргэжилтэн

Гадаадын иргэн, харьяатын газрын даргын 2021
оны 10 дугаар түшаалын тавдугаар хавсралт

ХЭВ ЖУРАМ САХИУЛАХ БҮЛГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

271225



Бүлгийн дарга:

Зөрчил шалган шийдвэрлэх газрын дарга

Гишүүд:

Хяналт шалгалт хариуцсан
хяналтын улсын ахлах байцаагч нар
Албадан гаргах ажиллагаа хариуцсан
хяналтын улсын ахлах байцаагч
Хяналтын улсын байцаагч нар
Мэдээлэл бүртгэлийн мэргэжилтэн

Гадаадын иргэн, харьяатын газрын даргын 2021
оны 12/93 дугаар тушаалын зургаадугаар хавсралт

НӨӨЦ, ХАНГАЛТ ХАРИУЦСАН БҮЛГИЙН БҮРЭЛДЭХҮҮН.



Бүлгийн дарга:

Санхүүгийн хэлтсийн дарга

Гишүүд:

Хөрөнгө оруулалт хариуцсан
ахлах мэргэжилтэн

Төсвийн ахлах мэргэжилтэн

Ахлах нягтлан бодогч нар

Нярав

Гадаадын иргэн, харьяатын газрын даргын 2021
оны 4/93 дугаар тушаалын долоодугаар хавсралт

ГАЛ УНТРААХ, АВРАХ БҮЛГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

1116126983 2712253



Бүлгийн дарга:

Хангарт, үйлчилгээний хэлтсийн дарга

Гишүүд:

Аж ахуйн менежер

Биеийн тамирын арга зүйч

Жолооч нар

Сантехник

Цахилгаанчин

Мужаан

Үйлчлэгч нар

Гадаадын иргэн, харьяатын газрын даргын 2021
оны язгуургаар тушаалын наймдугаар хавсралт



**ХОЛБОО, ЗАРЛАН МЭДЭЭЛЭЛ ХАРИУЦСАН
БҮЛГИЙН БҮРЭЛДЭХҮҮН**

Бүлгийн дарга:

Мэдээллийн технологийн хэлтсийн дарга

Гишүүд:

Өгөгдлийн сангийн инженер

Программ хангамжийн инженерүүд

Сүлжээний инженерүүд

Хэвлэлийн эх бэлтгэгч

Гадаадын иргэн, харьяатын газрын даргын 2021
оны 19 дугаар тушаалын есдүгээр хавсралт

ГАДААД ХАРИЛЦАА, ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ БҮЛГИЙН БҮРЭЛДЭХҮҮН



Бүлгийн дарга:

Гадаад харилцаа, хамтын ажиллагааны
хэлтсийн дарга

Гишүүд:

Гадаад харилцааны ахлах мэргэжилтэн
Гадаад харилцааны мэргэжилтэнүүд

Гадаадын иргэн, харьяатын газрын даргын 2021
оны 1/өздугаар тушаалын аравдугаар хавсралт

ЭРСДЛИЙН ҮНЭЛГЭЭНИЙ БҮЛГИЙН БҮРЭЛДЭХҮҮН



Бүлгийн дарга:

Хяналт-шинжилгээ, үнэлгээ,
аудитын хэлтсийн дарга

Гишүүд:

Хяналт шинжилгээ хариуцсан
ахлах мэргэжилтэн
Нийцлийн аудит хариуцсан ахлах мэргэжилтэн
Хяналт шинжилгээ хариуцсан мэргэжилтэн
Аудит хариуцсан мэргэжилтэн

Гадаадын иргэн, харьяатын газрын даргын 2021
оны 2712253
жилийн 2712253
бүлгүүдийн тушаалын арваннэгдүгээр хавсралт

**ОРОН ТООНЫ БУС ШТАБЫН ГИШҮҮД БОЛОН БҮЛГҮҮДИЙН
АЖИЛ ҮҮРГИЙН ХУВААРЬ**

I. Орон тооны бус штабын дарга:

1. Гамшигаас хамгаалах төлөвлөгөө боловсруулахад мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлж жил бүр тодотгох;
2. Тохиолдсон гамшигаас үүдэн хоёрдогч хөнөөл үүсэхээс урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах; Байгууллага дээр тохиолдож болзошгүй гамшиг осол, гал түймрийн аюулаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, аврах, сэргээн босгох арга ажиллагаанд мэргэжлийн анги, ажилтан албан хаагчдыг сурган дадлагжуулах;
3. Нуулгэн шилжүүлэх үед байр, хүнсний бүтээгдэхүүн, шатахуун тосолгооны материал, бусад нөөцийг бүрдүүлэх;
4. Харуул хамгаалалтыг чангатгах, эмх замбараагүй байдал үүсэхээс урьдчилан сэргийлж хэв журам сахиулах;
5. Гамшигт нэрвэгдсэн хүн ам, ажилтан албан хаагчдад анхны тусlamж үзүүлж эмнэлэгийн байгууллагад шилжүүлэх;
6. Гамшигийн голомтонд холбоо зохион байгуулах, Онцгой байдлын хэлтэс, дээд шатны байгууллагыг мэдээ мэдээллээр тасралтгүй хангах;
7. Тохиолдож болзошгүй гамшигийн төрлүүдээр мэргэжлийн байгууллагаар эмзэг байдал, эрсдлийн үнэлгээ хийлгэх;
8. Гамшигийн нөөц бүрдүүлэх, томилгоожсон мэргэжлийн ангийг хувцас, багаж хэрэгслээр хангах;
9. Удирдлагын байр, холбоо, мэдээллийн хэрэгслийг бэлэн байдалд оруулан жижүүрлэлт томилж, мэдээ мэдээллийг дараалал харгалзахгүй хүлээн авах, дамжуулах
10. Гамшиг, гал түймрийн нөхцөл байдлыг зурагт оруулах мэргэжлийн байгууллагын гаргасан шийдвэрийг газрын хэмжээнд хэрэгжүүлэх;
11. Объектын гал түймрийг унтраахад шаардлагатай багаж хэрэгслийг бэлтгэх, нөхөн хангарт хийх;
12. Техник хэрэгслийн бэлэн байдлыг хангуулах;

II. Орон тооны бус штабын нарийн бичгийн дарга:

1. Гамшигаас хамгаалах ажиллагааг төлөвлөх, хэрэгжүүлэх, өдөр тутмын үйл ажиллагааг удирдах;
2. Гамшигаас хамгаалах сургалтыг мэргэжлийн байгууллагатай хамтран зохион байгуулах;
3. Гамшиг ослын үед шаардлагатай багаж хэрэгслийн бэлэн байдлыг хангах;

III. Сургалт сурталчилгаа хариуцсан бүлэг:

1. Гамшигийн талаар болон хүний гоц халдварт өвчний шинж тэмдэг илэрсэн үед дүүргийн онцгой байдлын комиссоос халдварт хамгааллын дэг журмыг мөрдүүлэх талаар гаргасан шийдвэрийг хэрэгжүүлэх, ажилтан албан хаагчдын дунд ариун цэвэр эрүүл ахуйн талаар явуулах сурталчилгээг эрчимжүүлэх арга хэмжээг авах зэрэг асуудлыг төлөвлөн ажиллах;
2. Гамшигаас хамгаалах сургууль дадлага явуулахад шаардлагатай танхим, дадлагын талбай бэлтгэх асуудлыг хариуцах;

3. Гамшгаас хамгаалах хууль тотоомж, холбогдох дүрэм журмыг газрын хэмжээнд сурталчилах;

IV. Холбоо зарлан мэдээлэл хариуцсан бүлэг:

1. Гамшгийн аюулаас урьдчилан сэргийлэх, гамшгийн үеийн зарлан мэдээллийг шуурхай дамжуулах;
2. Дээд шатны мэргэжлийн байгууллагад гамшгийн нөхцөл байдлыг дамжуулах, мэдээлэл солилцох;
3. Холбоо зарлан мэдээлэл дамжуулах техник хэрэгслийн бэлэн байдлыг хангуулах;

V. Хэв журам сахиулах бүлэг:

1. Гамшгийн голомтод хэв журам сахиулах, албан хаагчид болон үйлчлүүлэгч нарыг нүүлгэн шилжүүлэх үед аюулгүй байдлыг хангах, нийтийг хамарсан эмх замбараагүй байдлыг үсгэхээс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, хорио цээрийн дэглэм сахиулах, харуул хамгаалалтыг зохион байгуулах чиглэлээр мэргэжлийн байгууллагын дадлага сургалтанд хамрагдах;
2. Гамшиг осол тохиолдсон үед албан хаагчдын болон үйлчлүүлэгчдийн аюулгүй байдлыг хангах, хэв журам сахиулах;
3. Шуурхай албаны автомашиныг голомтод саадгүй нэвтрүүлэх;
4. Зарлан мэдээлэл хариуцсан туслахтай хамтран ажиллах;

VI. Нөөц, хангалт хариусан бүлэг:

1. Гамшгаас хамгаалах сургалт, дадлагын үед болон гамшгийн хор уршгийг арилгахад шаарддагдах техник хэрэгсэл, бусад нөөц хөрөнгөөр /ус, хүнс г.м/ хангах;
2. Гал түймэртэй тэмцэх багаж хэрэгслийн нөөцийг бүрдүүлж бэлэн байдлыг хариуцах;
3. Дадлага сургалт болон үүссэн нөхцөл байдлыг үнэлж хангалтыг зохион байгуулах;

VII. Эмнэлгийн тусlamж үйлчилгээ үзүүлэх бүлэг:

1. Гамшиг ослын үед албан хаагчдад болон үйлчлүүлэгчдэд эмнэлгийн анхан шатны тусlamж үзүүлэх чиглэлээр мэргэжлийн байгууллагын албан хаагчдаар дадлага, сургалт зохион байгуулж хамрагдах;
2. Гамшиг осол тохиолдсон үед албан хаагчид болон үйлчлүүлэгчдэд эмнэлгийн тусlamж дуудаж, Эмнэлгийн анхны тусlamж үйлчилгээ үзүүлэх;

VIII. Гал унтраах, аврах бүлэг:

1. Байгууллагад гарсан объектийн түймрээс албан хаагчдын болон үйлчлүүлэгч нарын амь нас, эд хөрөнгийг авран хамгаалах, өөрийн нөөц боломжийн хүрээнд гал түймрийг унтраах арга хэмжээ авч Онцгой байдлын газарт мэдэгдэх
2. Гал түймрээс урьдчилан сэргийлэх, тэмцэх, авран хамгаалах, гал унтраах багаж хэрэгсэлтэй хэрхэн ажиллах талаар албан хаагчдад мэргэжлийн байгууллагаас сургалт авч зохион байгуулах;
3. Гамшиг, гал түймэр гарсан тохиолдолд Гамшгаас хамгаалах төлөвлөгөөний дагуу хурдан шуурхай ажиллах;
4. Барилга, объектын галын аюулгүй байдлыг хангах, усны эх үүсвэр, гал унтраах багаж хэрэгслийн бүрэн бутэн байдалд тогтмол үзлэг хийх;
5. Гамшгаас хамгаалах хууль тогтоомж, гамшгийн хор уршгийн талаар ажилтан, албан хаагчдад ухуулга сурталчилгаа хийх;

IX. Архивын баримтыг нүүлгэн шилжүүлэх бүлэг:

1. Архивын баримтыг аюулгүй газарт нүүлгэн шилжүүлэх ажлыг шуурхай зохион байгуулах
2. Нүүлгэн шилжүүлэх явцад архивын баримт үрэгдэх, алга болохоос урьдчилан сэргийлэх
3. Гамшиг ослын үед албан хаагчдад архивын баримтыг нүүлгэн шилжүүлэх, аюулгүй газарт хадгалах чиглэлээр мэргэжлийн байгууллагын албан хаагчдаар дадлага, сургалт зохион байгуулж хамрагдах;

X. Гадаад харилцаа, хамтын ажиллагааны бүлэг:

1. Шаардлагатай тохиолдолд цар тахлын халдвараас урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээ авах ажлын хүрээнд Монгол улсад суугаа гадаад орнуудын дипломат төлөөлөгчийн газар, олон улсын байгууллагатай хамтран ажиллах үйл ажиллагааг зохион байгуулах
2. Байгууллагаас гамшиг, цар тахалтай холбоотой гадаадын иргэдэд хүргэх мэдээ, мэдээллийг орчуулах, нийтэд түгээх

XI. Эрсдлийн үнэлгээний бүлэг:

1. Байгууллагад учирч болох гамшиг, цар тахлын халдварын эрсдлээс урьдчилан сэргийлэх, үнэлгээ хийх үйл ажиллагааг хэрэгжүүлэх
2. Эрсдлийн үнэлгээний хүрээнд цаашид авч хэрэгжүүлэх үйл ажиллагааг байгууллагын гамшгаас шуурхай штабын гишүүд болон холбогдох мэргэжлийн байгууллагатай хамтран зохион байгуулах

НЭГ. ГАМШГИЙН ҮЕД АЖИЛЛАХ ЖУРАМ

Гамшгаас хамгаалах тухай хуульд “Гамшгаас хамгаалах хүч хэрэгсэл нь Онцгой байдлын асуудал эрхэлсэн байгууллага, гамшгаас хамгаалах чиг үүрэг бүхий албад, аж ахуйн нэгж байгууллага, мэргэжлийн анги болон сайн дурынхан байна” гэж тодорхойлсон.

Энэхүү төлөвлөгөө нь Гамшгаас хамгаалах тухай хууль, “Гамшгаас хамгаалах талаар төрөөс баримтлах бодлого”, “Гамшгаас хамгаалах чадавхийг бэхжүүлэх үндэсний хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх, гамшгийн аюулаас урьдчилан сэргийлэх, аврах, хоошлиулшгүй сэргээн босгох ажиллагааны үед эрхэлсэн салбарынхаа хэмжээнд гамшгаас хамгаалах арга хэмжээг төлөвлөх, хэрэгжилтийг зохион байгуулах, салбарын онцлогт зохицуулан гамшгаас хамгаалах албаны удирдлага, штаб байгуулах, тэдгээрийн сургалт бэлэн байдал, гамшгийн үед тогтвортой ажиллагааг хангах, шаардагдах техник, хүч хэрэгслийг бүрдүүлэх, бэлэн байлгах ажлыг холбогдох хууль тогтоомж, эрх зүйн актын дагуу зохион байгуулж гүйцэтгэх үед мөрдөж ажиллах, гамшгаас хамгаалах менежментийн тогтолцоог бэхжүүлэх, гамшгийн эмзэг байдлыг бууруулах, үйл ажиллагааны чадавхийг сайжруулан гамшгаас хамгаалах хүч хэрэгслийн чадавхийг бэхжүүлэх удирдлагын баримт бичиг юм.

Төлөвлөгөөг 2 хувь үйлдэх бөгөөд нэг хувийг нийслэлийн Хан-Уул дүүргийн Онцгой байдлын хэлтэст, хоёр дахь хувийг Гадаадын иргэн, харьяатын газрын Дүн шинжилгээ, дотоод аудитын хэлтэст тус тус хадгална.

Гамшгаас хамгаалах төлөвлөгөөнд дор дурдсан чиг үүргийг тусгаж ажиллана. Үүнд:

Гамшгаас хамгаалах хууль тогтоомж, дээд шатны байгууллагаас гамшгаас хамгаалах асуудлаар гаргасан шийдвэрийн гүйцэтгэлийг хангах.

Газрын онцлогт тохируулан гамшгаас хамгаалах албаны удирдлага, штаб, мэргэжлийн ангийг байгуулах, тэдгээрийн сургалт, бэлтгэл, бэлэн байдлыг хангуулах.

Гамшгийн үед салбарын тогтвортой байдлыг хангах.

Зарлан мэдээллийн системийг байнгын бэлэн байдалд байлгах.

Гамшгийн аюулаас урьдчилан сэргийлэх, хор уршигийг арилгах, хоошлиулашгүй сэргээн босгох арга хэмжээнд татан оролцуулах техник материал хэрэгсэл зэрэг тухайн албанд шаардагдах нөөцийг бүрдүүлэх, бэлэн байлгах.

Гамшгаас хамгаалах асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад гамшгийн цагийн байдлыг шуурхай мэдээлэх, мэргэжлийн туслапцаа авах.

Гамшигтай холбогдуулж хувиарлагдсан мөнгийг зориулалтын дагуу зарцуулах.

Төлөвлөгөөг хэрэгжүүлэхтэй холбогдсон арга хэмжээний зардлыг Гадаадын иргэн, харьяатын газрын төв, орон нутгийн байгууллага, албадын жил, хэтийн төлөвлөгөө болон төсөвт тусгаж хэрэгжүүлнэ.

**Гамшгаас хамгаалах бэлэн байдлын зэргүүдэд
дараах үүргийг гүйцэтгэнэ**

a/ Өдөр тутмын бэлэн байдлын үед: Албаны онцлогтой нийцүүлэн гамшгаас хамгаалах төлөвлөгөө боловсруулан мөрдөх, холбоо, зарлан мэдээллийн системийг бэлэн байдалд байлгах, тогтоосон дохиогоор ажиллах арга ажиллагаанд албан хаагчдыг сургах,

бэлэн байдлыг дээшлүүлэх, гамшгийн нөөц бүрдүүлэх, гамшгаас хамгаалах сургалт, бэлтгэлийг зохион байгуулах.

б/ Өндөржүүлсэн бэлэн байдлын үед: Албан хаагчдад зарлан мэдээлэх дохиог хүргэх, гамшгаас хамгаалах хамгаалах төлөвлөгөөнд тодотгол хийх, шуурхай удирдлагын бүрэлдэхүүн, удирдлагын байр, холбоо, мэдээллийн хэрэгслийг бэлэн байдалд оруулах, хүч, техник, материад хэрэгслийг дайчлан гаргах ажлыг цагийн байдлаас шалтгаалан төлөвлөгдсөн арга хэмжээг бүрэн буюу хэсэгчилсэн байдлаар хэрэгжүүлэх, гамшгийн нөөцийг нэмэгдүүлж, гамшгаас хамгаалах арга хэмжээнд дэмжлэг үзүүлж ажиллана.

Өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт бүрэн шилжүүлсэн үед штаб, түүний хүч хэрэгсэл төлөвлөгөөт арга хэмжээг бүрэн хэрэгжүүлэх ба хэсэгчилсэн байдлаар шилжүүлсэн үед албаны зарим хүч хэрэгслийг шилжүүлэх буюу төлөвлөгөөт арга хэмжээг хэсэгчлэн хэрэгжүүлнэ.

в/ Бүх нийтийн бэлэн байдлын үед:

- Өндөржүүлсэн бэлэн байдлын үеийн арга хэмжээг нэгэн зэрэг хэргэжүүлнэ.
- Гамшгаас хамгаалах албаны удирдлага, мэргэжлийн ангиуд, хүн ам хүрээлэн буй орчныг гамшгийн аюулаас аврах, хор уршигийг арилгах, хоошлуулшгүй сэргээн босгох төлөвлөгөөт арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.
- Гадаадын иргэдийн шилжилт хөдөлгөөн, тэдгээрийг нүүлгэн шилжүүлэх асуудлыг шуурхай штабаас гаргасан шийдвэрийн дагуу хэрэгжүүлнэ.

ХОЁР. ГАМШГИЙН ҮЕД ДУУТ ДОХИОГООР АЖИЛЛАХ ЖУРАМ

“Агаарын түгшүүр” дохио

Улсын хил болон нутаг дэвсгэрт онгоц, пуужин бусад нисэх хэрэгслийн дайралтын аюул заналхийлсэн баталгаатай дохио авсан тохиолдолд Улсын онцгой байдлын ерөнхий газрын шуурхай жижүүр холбооны нэгдсэн сүлжээгээртөвлөрсөн зарлан мэдээллийн системийг ашиглан аймаг нийслэлийн цахилгаан дохиологчоор 3 минутын турш зарлана.

Мөн үүний зэрэгцээгээр шуурхай жижүүрээс 2-3 минутын турш холбоо радио, телевизээр тухайн чиглэлд болон орон даяар “Иргэдээ, Анхаараарай, Анхаараай. Гамшигаас хамгаалах штабаас ярьж байна. Агаарын түгшүүр, Агаарын түгшүүр, Агаарын түгшүүр” гэж зарлана.

Уг дохиог хүлээн авсан засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, байгууллагын дарга нь холбоо радио, телевиз чанга яриг болон бусад техник хэрэгслээр түүнийг өөрийн нутаг дэвсгэрийн хүн амд дахин давтан дамжуулна.

Дохио өгсөн үед хэрхэн ажиллах талаар тайван цагт хүн амд зааж сургасан байх ёстой.

Ажил, албан газарт байх үед:

- Албан байгууллагын тогтоосон журам, зааврын дагуу ажиллана.
- Гэрэл өнгөлөн далдлах арга хэмжээг авна.
- Нэг бүрийн хамгаалах хэрэгслээ “аяны байдалд” авч өмсөхөд бэлтгэнэ.
- Хоргодах далдлах байранд нэн даруй орно.
- Тээврийн хэрэгслийн жолооч нар авто машинаа зогсоож хаалгаа нээнэ.
- Ажлын байрны цахилгааныг салгаж зарим тоног төхөөрөмжийг аюулгүй байдалд оруулна.

Олон нийтийн үйлчилгээний газар байх үед:

- Тухайн байгууллагын удирдлагаас өгсөн зааврыг анхааралтай биелүүлж ажиллана.
- Нэг бүрийн хамгаалах хэрэгслээ өмсөхөд бэлтгэнэ.
- Зааж өгсөн ойр байгаа хамгаалах байгууламжинд орно.

Гэртээ байх үед:

- Зуух пийшин дэх галаа унтрааж цахилгаан хэрэгслийг шугамнаас салгана.
- Нэг бүрийн хамгаалах хэрэгслээ өмсөхөд бэлтгэнэ
- Амархан муудахгүй хүнсний зүйл усны нөөц, эмнэлгийн анхны тусламж үзүүлэх зүйлс бичиг баримт зэргийг авна.
- Ойр байгаа хамгаалах байгууламжинд нэн даруй орно.
- Хэрэв хамгаалах байгууламж байхгүй бол газар орны хамгаалах боломжийг ашиглана.

Гадаа гудамжинд байх үед:

- Тээврийн хэрэгслээр явж байсан бол зогсмогц бууж гадагш гарна.
- Ойр байгаа хамгаалах байгууламжинд нэн даруй орно.
- Хэрэв хамгаалах байгууламж байхгүй бол газар орны хамгаалах боломжийг ашиглана.
- Аль ч тохиолдолд гамшигаас хамгаалах байгууллага, нийгмийн хэв журам сахиулах мэргэжлийн ангийн өгсөн захирамжийг анхааралтай сонсож, тэр дагуу ажиллана.

“Агаарын түгшүүр өнгөрлөө” дохио

Дайсны нисэх онгоц, пуужин болон бусад хэрэгслийн дайралтын аюул өнгөрсөн тухай мэдээг гамшигаас хамгаалах шуурхай жижүүрээс холбоо, радио телевиз, чанга яригчаар “Иргэдээ, Анхаараарай, Анхаараарай, Гамшигаас хамгаалах штабаас ярьж байна. Агаарын түгшүүр өнгөрлөө. Агаарын түгшүүр өнгөрлөө.” гэж 2-3 минутын турш зарлан мэдээлнэ.

Хөнөөл довтолгоо болон гамшигт өртсөн хот газарт учирсан хохирлыг арилгах, цаашид хүн ам хэрхэн ажиллах талаар дагаж мөрдөх горим болон буёад шаардлагатай мэдээллийг нийтэд мэдээлж зарлана.

Аюул учирсан тухай болон цаашид сахих журам, горимын тухай ГХШ-аас мэдэгдэх хүртэл зөвшөөрөлгүйгээр хоргodoх далдах байрнаас гарах, нэг бүрийн хэрэгслээ тайлахыг хориглоно.

Тусгайлан дохио тогтоогүй гамшиг ослоос урьдчилан сэргийлэх хамгаалах арга хэмжээг урьдаас зохион байгуулах зорилгоор “усны аюул боллоо”, “Гал түймрийн аюул боллоо”, “Цас зудны аюул боллоо”, “Газар хөдлөлтийн аюул боллоо”, “Үйлдвэрийн осол аюул боллоо” гэсэн сэрэмжлүүлэх мэдээллийг тухайн үед нь мэдээллийн хэрэгслээр дамжуулна.

Дээрх дохионуудын утга, дохиогоор ажиллах журмыг хүн амд мэдүүлсэн байх бөгөөд тайван цагт сургууль хийж, дадлагын үед ашиглаж болно.

ГУРАВ. БАЙГУУЛЛАГЫН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

Гадаадын иргэдийн асуудлыг эрхлэх талаар анх 1924 онд Засгийн газрын шийдвэрээр Улаанбаатар хотын захиргаанд гадаадын иргэдийн бүртгэлийн хэлтсийг, 1994 онд Засгийн газрын 107 дугаар тогтоолоор Гадаадын иргэн, харьяатын асуудал эрхлэх зөвлөлийг Хууль зүйн сайдын дэргэд байгуулж, улмаар Засгийн газрын 2001 оны 71 дүгээр тогтоолоор Гадаадын иргэн, харьяатын асуудал эрхлэх алба, Засгийн газрын 2008 оны 64 дүгээр тогтоолоор Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Гадаадын иргэн харьяатын асуудал эрхлэх газар болон өргөжсөн.

Хилийн боомтын тухай хууль 2014 оны 04 дүгээр сарын 01-ний өдрөөс хэрэгжиж эхэлсэнтэй холбогдуулан Засгийн газрын 2014 оны 101 дүгээр тогтоолыг үндэслэн Хил хамгаалах ерөнхий газрын хилийн шалган нэвтрүүлэх чиг үүргийг хэрэгжүүлж байсан 400 орон тоог Гадаадын иргэн, харьяатын асуудал эрхлэх газартай нэгтгэн 617 албан хаагч бүхий Иргэний харьяалал, шилжилт хөдөлгөөний ерөнхий газар болгон өөрчлөн зохион байгуулсан.

Улмаар “Засгийн газрын агентлагийн талаар авах зарим арга хэмжээний тухай” Засгийн газрын 2016 оны 07 дугаар сарын 27-ны өдрийн 4 дүгээр тогтоолоор Гадаадын иргэн, харьяатын газрын орон тооны хязгаар, Хууль зүй дотоод хэргийн сайдын 2017 оны 01 дүгээр сарын 31-ны өдрийн А/24 дүгээр тушаалаар “Байгууллагын үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр, зохион байгуулалтын бүтэц орон тоо”, Гадаадын иргэн, харьяатын газрын даргын 2017 оны 02 дугаар сарын 01-ний өдрийн Б/51 дүгээр тушаалаар орон нутаг дахь нэгжийн зохион байгуулалтын бүтэц зохион байгуулалтыг тус тус шинэчлэн баталсан. Тус байгууллага нь Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай, Харьяатын тухай болон бусад холбогдох хууль тогтоомжийн хүрээнд:

- Монгол улсад зорчих түр ирэгч, албан болон хувийн хэргээр оршин суух гадаадын иргэнд виз, визийн зөвшөөрөл, оршин суух зөвшөөрөл олгох, хугацааг сунгах хувийн урилга олгох, гадаадын иргэнийг цахим үнэмлэхжүүлэх;
- Монгол улсаас гадаад улсад суугаа дипломат төлөөлөгчийн болон консулын газарт мэргэжил арга зүйн туслалцаа үзүүлэх;
- Цагаачлал, гадаадын гэр бүлд Монгол улсын харьят хүүхэд үрчлүүлэх, олон улсын болон гадаадын төрийн бус байгууллагын салбар, төлөөлөгчийн газартай холбоотой асуудлыг шийдвэрлэх;
- Гадаадын иргэдийн хяналт, виз, визийн зөвшөөрлийн, мэдээллийн нэгдсэн сан байгуулах, хөтлөх;
- Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай болон холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих, илэрсэн зөрчлийг шийдвэрлэх үүргийг хэрэгжүүлж ажилладаг.

Гадаадын иргэн, харьяатын газар нь газар зүйн хувьд Улаанбаатар хотын Хан-Уул дүүргийн 10 дугаар хороо Буянт-Ухаа дэнжийн нутаг дэвсгэрт байрладаг. Өөрийн эзэмшилийн 15000 м.кв талбайтай, улсын бүртгэлийн дугаар 9070002018, регистр №2712253 гэрчилгээтэй. Улаанбаатар хотын Хан-Уул дүүрэг 10 дугаар хороо болон Чингис хаан олон улсын нисэх буудлын цахилгаан эрчим хүч, дулаан, ус холбоо хотын нэгдсэн сүлжээнд холбогдсон. Биологийн бохирдол байхгүй. Хотын төв хэсэг гэр хорооплоос зайдуу учир химиин бохирдол хотын дундаж түвшинтэй ижил, газар ашиглалтын зөрчилгүй.

Байгууллагын төв байр 2009 онд, 2-р байр 2011 онд тус тус ашиглалтанд орсон. Барилгын насжилт залуу. Хүн ам зүйн хувьд ерөнхий газрын хэмжээнд орон тооны хувьд 65 эрэгтэй, 42 эмэгтэй албан хаагчтай ажиллаж байна. Гадаадын иргэн, харьяатын газрын хэмжээнд суудлын 4 автомашин, ажилчдын 1 автобус, аж ахуйн үйлчилгээнд 2 микро автобус, хяналт шалгалтын газарт 1 микро автобус хөдөө орон нутагт явах түүлах чадвар сайтай 2

автомашинаар хангагдан үйл ажиллагаа явуулдаг бөгөөд сүүлийн 10 жилийн байдлаар, объектын гол түймэр, хүн, мал амьтны гоц халдварт өвчин, хүчтэй цасан болон шороон шуурга, газар хөдлөлт, террорист халдлага техникийн осол тохиолдож байгаагүй болно.

ДӨРӨВ. МОНГОЛ УЛСАД ТОХИОЛДОЖ БОЛЗОШГҮЙ ГАМШИГ ТҮҮНД ХИЙХ ДҮГНЭЛТ

Монгол орон нь дэлхийн бөмбөрцгийн зүүн хагаст Төв Азийн хойд хэсэгт, Дорнод Сибирийн их ой, тайгад аажим шилжих завсрын бүсэд оршдог.

Нийт 1,564,116 км² талбай нутаг дэвсгэрийг эзэлж, баруунаас зүүн хүртэл 2392 км урт, хойноос урд хүртэл 1259 км өргөн газар нутагтай. Газар нутаг бүхэлдээ далайн түвшнээс дээш 552 м /Хөх нуурийн хотгор/ бол хамгийн өндөр газар нь далайн түвшнээс дээш 4374 м /Хүйтэн оргил/ ба нийт нутаг дэвсгэрийн 81,2 хувийг амьсгалийн сэргүүн, хуурай, эх газрын эрс тэс, хатуу ширүүн болгох гол хүчин зүйл болж байдаг. Дөрвөн улиралтай ба өвлийн дундаж температур -15...-30C (6...22F), зун нь 10...26,7C (50...80F) байна.

Монгол оронд хур тундас ерөнхийдөө бага ордог, Хангайн нуруу, Хөвсгөл, Хэнтийн уулсаар 300-400 мм, Монгол Алтайн болон ойт хээрийн бүсэд 250-300 мм, хээрийн бүсэд 150-250 мм, говь цэлийн бүсэд 150-50 мм орчим хур тунадас унана. Хур тунадасны 85% орчим нь жилийн дулаан улиралд /6-9 сард/ үүнээс зөвхөн 7,8 дугаар сард 50-60% нь орно. Монгол оронд үүлшил бага, цэлмэг өдрийн тоо их, жилдээ 230-260 хоног байх тул жилдээ 2600-3300 цаг нар гийгүүлнэ.

Дэлхийн уур амьсгал 20 дугаар зуунд 0,74 градусаар дулаарсан байхад, эх газрын гүнд оршдог, эрс тэс уур амьсгалтай манай орны хувьд зөвхөн 1940 оноос хойш агаарын дундаж температур 2,1 градусаар дулаарч, үүний улмаас хур тунадас татрах, хуурайших, ган, зуд, хүчтэй салхи шуурганы давтамж нэмэгдэх зэрэг сөрөг нелөөлөл үзүүлдэг. Нийт нутгийн 41,3%-ийг эзлэх говь цэлийн бүсэд сул шороо элбэг, салхи ихтэй тул шороон шуурга олонтаа тохиолдно. Энэ бүс нутагт жилдээ 30-100 өдөр, Монгол элсний өмнөд захад жилдээ 120 өдөр шороо хийсдэг ажээ. Монголын шороон шуурга бол Зүүн Азийн "шар тоос"-ны нэг гол эх үүсвэр юм.

A. БАЙГАЛИЙН ГАРАЛТАЙ ГАМШИГ

Цасан болон шороон шуурга: Монгол орны нийгэм, эдийн засгийн цөм болсон бэлчээрийн мал аж ахуйд ихээхэн сөрөг нелөө үзүүлдэг цаг агаарын нэн аюултай буюу гамшигт үзэгдлүүдийн нэг нь хүчтэй салхи, цасан болон шороон шуурга шуурах явдал юм.

Цасан болон шороон шуурганы улмаас хүний амь нас, эрүүл мэнд хохирох, мал амьтан олноор хорогдох, эд хөрөнгө ихээр эвдээр сүйддэг. Тухайлбал хүчтэй цасан шуурганы үед мал үруудаж малчид малаа даган төөрч осгохоос гадна малын хашаа хороонд цас дүүрч мал сурэг хашаа хороондоо цасанд дарагдах авул байдаг бол шороон шуурга нь газрын хөрсийг их хэмжээгээр элэгдүүлэх мөн мал уруудах, тээврийн зам хаагдах улмаар хээр явж буй хүмүүс төөрч осолдох зэрэг олон хэлбэрээр хор уршиг учруулдаг.

Хүчтэй салхи, шуурганы аюул жилд дунджаар 15 удаа тохиолдож үүний улмаас 24 хүн амь наасаа алдаж, 100 шахам мянган толгой мал хорогдож, 825 сая төгрөгийн хохирол учруулж байна.

Үер: Үер нь давтагдах тоо, хамрах хүрээ, жилд учруулах эдийн засгийн нийлбэр хохирлын хэмжээгээр байгалийн гаралтай аюулт үзэгдлүүд дотроос ямагт тэргүүлэх байр эзэлдэг.

Манай оронд цаг агаарын огцом дулаарлын нөлөөгөөр хайлсан цас, мөс уулын бэл, жалга судаг, хоолой хөндийгөөр ус урсах, усанд автах, голын ус эргээсээ халих, татам болон голын эрэг орчмын газар усанд автах үед үүсэх шар усны үер, хур бороо, хайлсан цас мөсний устай гадаргын сэвсгэр хурдас, чулуулаг холилдон газрын хэвлэй даган урсах хүчтэй хуйлраа урсгал бүхий уруйн үер, эрчишил ихтэй аадар болон зүс борооноос голын усны түвшин богино хугацаанд нэмэгдэн ус эргээ хальж татам болон эрэг орчмын газар усанд автсанаас үүсэх хур борооны үер зэрэг 3 төрлийн үер тохиолддог.

Сүүлийн 10 жилийн байдлаар манай оронд үерийн аюул жилд дунджаар 13 удаа тохиолдож, 10 орчим хүн амь насаа алдан, сая шахам толгой мал хорогдож, 595,9 сая төгрөгийн хохирол учруулж байна.

Зуд: Монгол орны нутаг дэвсгэрийн ихэнх, эсхүл аль нэг хэсгийг хамарсан зуд барагцаалбал 2 жилд давтагдаж үүний улмаас бэлчээрийн мал аж ахуй их хэмжээний хохирол амсдаг байна. Сүүлийн 60 гаруй жилийн 65%-д нь их өөга хэмжээтэй зуд тохиолдож байсан бөгөөд статистик судалгаанаас үзэхэд тохиолдож буй зудын улмаас жил тутам дунджаар 206 мянган мал харин 1944-1945 онд 8,3 сая, 1950 онд 3,5 сая, 1967-1968 онд 2,9 сая, 1976-1977 онд 2,1 сая, 2000-2002 онд 8,7 сая, 2010 онд 9,7 сая толгой мал хорогдсон. Зөвхөн сүүлийн 10 жилийн хугацаанд 19.380.000 гаруй толгой мал хорогдоод байна.

Ган: Ган нь газар тариалан, нүүдлийн мал аж ахуйд ихээхэн бэрхшээл учруулдаг бөгөөд ган болоход мал сүрэг бэлчээр усаар гачигдаж турж үхэх аюул нүүрлэдэг бол таримал ургамал чийгийн хомсдолд орж сүйрнээр хүн ам хүнс тэжээлээр хомсдох тохиолдол гардаг.

1941 оноос хойших 70 жилийн хугацаанд 11-ээс бусдад нь манай орон ямар нэг гантай болон гандуу байсны дотор мэргэжлийн байгууллагын тодорхойлсноор 1944 оны зун нийт нутаг дэвсгэрт улаан ган болжээ. Ялангуяа сүүлийн 10 жилд ган их тохиолдож байгаа бөгөөд хамгийн их хохирол учруулсан ган 1999-2002 онд болж нийт нутаг дэвсгэрийн 50-70% өртсөн.

Аянга: Хэдийгээр хамрах нутаг дэвсгэрийн хувьд бага ч аянга нь онцгой аюултай байдаг. Жилийн 4 улиралтай манай орны зуны улиралд тохиолдох аянганы учруулах хор уршиг цаг агаарын гаралтай бусад аюулудыг бодвол харьцангуй бага. Гэхдээ аянганы аюулд өргөн уудам газар нутагт тархай бутархай суурших хөдөөгийн малчид өртөж амь насаа алдах, гэмтэх, эд хөрөнгөөрөө хохирох явдал нилээдгүй тохиолддог.

Жилд дунджаар 5 удаа энэ үзэгдэл тохиолдож үүний улмаас 4 хүн амь насаа алдаж, 200 шахам толгой мал хорогдож, 48,8 сая төгрөгийн эдийн засгийн шууд хохирол учирсан байна.

Газар хөдлөлт: Газар хөдлөлт нь зам, гүүр, барилга байгууламжийг нурааж, хий, цахилгаан, утасны шугам, хоолойг сүйтгэн хөрсний нуралт, цасан нуранга, үер, гал түймэр, үүсгэдэг ихээхэн хор уршигтай аюулт үзэгдэл юм. Нэн ялангуяа хүн ам ихээр суурьшсан бус нутагт газар хөдлөлт болох нь илүү олон хүн бэртэж, гэмтэх, үхэх, их хэмжээний хөрөнгө сүйрэх аюултай байдаг.

Монгол Улсын хэмжээнд жилд дунджаар 1000-1500 удаа газар хөдлөлтийн чичирхийлэл бүртгэгдсэнээс 3-5 удаа тохиолдол нь мэдэгдэм хүчтэй буюу 4-5 магнитудын хүчтэй газар хөдлөлт болдог байна.

Сүүлийн 50 гаруй жилийн хугацаанд Монгол улсын нутаг дэвсгэрт хийгдсэн газар хөдлөлтийн судалгаанаас хараад манай улсын хот, суурин гаазрын 75 орчим хувь эх газар хөдлөлтийн 7 ба түүнээс дээш, 12 сум суурин газар нь 9 баллаас дээш бус нутагт оршиж байна. 7 ба түүнээс дээш балл бүхий газар хөдлөлтийн бус нутагт манай улсын нийт хүн амын 60 гаруй хувь нь хот, суурин газарт байнгын оршин суудаг ба зөвхөн нийслэлд 40-50 орчим хувь нь амьдарч байна.

Хүний гоц халдварт өвчин: Хүний гоц халдварт өвчин нь богино хугацаанд олон хүнд дамжин халдварлаж улмаар улс орны болон олон улсын аюулгүй байдалд ноцтой нөхцөл байдал үүсгэдэг.

Хүний гоц халдварт өвчнийг олон улсын хөл хориот өвчин, байгалийн голомтот халдварт өвчин гэж ангилдаг. Олон улсын хөл хориот өвчин гэж урьдчилан тэмцэх арга хэмжээ нь олон улсын ариун цэврийн дүрмээр зохицуулагддаг өвчинг хэлнэ. Эдгээрийн онцлог нь маш богино хугацаанд дэгдэлт хэлбэрээр маш олон хүнд дамжин халдварлаж, улс орны дотор болон олон улсын хэмжээнд гамшгийн нөхцөл байдал үүсгэдэг.

Байгалийн голомтот халдварт өвчин гэж үүсгэгч нь байгаль дээр мал, амьтан, ургамлын дунд оршиж, байгалийн нутагшмал голомт үүсгэн, мэл эмьтны хооронд халдварлал явагдаж энэ халдварт хүн хөндлөнгөөс өртөн өвчлөхийг хэлнэ.

Мал, амьтны гоц буюу аюулт халдварт өвчин: Дэлхийн мал, амьтаны эрүүл мэндийн байгууллага малын халдварт өвчнийг мал аж ахуйд учруулдаг эдийн засгийн, нийгмийн хохирлыг үндэслэн гоц халдварт "А", аюулт халдварт "Б" гэсэн 2 ангилалд хуваан үздэг.

Олон улсын хэмжээнд мал, амьтаны 15 нэр төрлийн гоц халдварт өвчин бүртгэгдсэнээс шүлхий, гахайн сонгомол мялзан, ньюкасел, хонины цэцэг, шувууны томуу өвчин манай улсад сүүлийн 10 жилийн хугацаанд гарсан.

